



**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

**Хөрөнгө бүртгэх тухай**

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.1 дэх заалт, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк хаалттай хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.4-т заасны дагуу шинээр бий болсон нийт 1,014,348,731.00 (нэг тэрбум арван дөрвөн сая гурван зуун дөчин найман мянга долоон зуун гучин нэг) төгрөгийн өртөг бүхий үерийн байгууламжийг байгууллагын хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө бүртгэлд авсан шийдвэрийн хуулбарыг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Г.Ганцэцэг)-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.РАДНААБАЗАР